



НОГООН ТЭЖЭЭЛ

Баян-Өлгий
аймгийн Сагсай
сумын СБАХ

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА: 2020 ОНЫ 4- 9 САР

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, 3,490,000 ТӨГ:

Төсөл хэрэгжсэн газар

Баян-Өлгий аймаг, Сагсай сумын Турган голын гүүрийн доод 2-5 га газар

Төслийн зорилго

Малчин өрхүүдийн хадлан хамгаалах, тэжээл тариалж малын тэжээл бэлтгэж бэлчээрийн даацыг буруулах ухаанд сургах, бэлчээр нутгаа өнжөөж, сэргээж хамгаалсанаар тогтмол орлоготой болгож амьжиргааг нь дээшлүүлэх, мөн малчин иргэд хямд өвсөөр малаа тэжээж зудаас хамгаалахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Төслийн зорилтууд

1. Малчин болон мал маллаж байгаа сумын иргэдийг хямд өвсөөр хангах.
2. Ядуу орлого багатай малчин өрхүүдийн амьжиргааг сайжруулаж, нүүх бололцоотой болгох.

3. Хадлангийн газраас хадлан бэлтгэх мэдлэг, чадвар, дадал олгох.

4. Ядуу эмзэг бүлгийн өрхүүдийг байнгын борлуулалтын сувагтай, эргэлтийн хөрөнгөтэй, өрхийн үйлдвэрлэгч нар болох.

Үйл ажиллагаа:

- Судалгаа хийж, шаардлагатай мэдээлэл цуглуулах
- Төсөл боловсруулж, санхүүгийн тооцоолол гаргах, шаардлагатай бусад мэдээлэлээр санхүүжүүлэгч олох
- Газраа түрээсээр болон эзэмшилээр авах
- Зусланд гардаг малчин өрхийг болон эмзэг бүлгийн өрхүүдийг сонгох
- Хадлан бэлтгэх, тэжээл овъёос тариалах
- Хадлан, тэжээлийг хураах, хадгалах

Төслийн хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Санхүүжилт, төгрөг
Төслөөс	1,500,000
ОНХС	
СБАХ	
Малчид	1,990,000
Нийт	3,490,000

Төслийн санхүүжилт буцалтгүй



Тариалалт хийхийн өмнөх талбайн байдал



Намар ургац хураахын өмнөх байдал.



Тэжээлээ хурааж малчин өрхүүд авч байгаа үе.



Хашаандаа буулгаж нөөцэлсэн байдал



Хадаж байгаа үеийн зураг

Сургамж.

Малчдын хэсэг, бүлгүүдийн малчид үнэн сэтгэлээсээ нийлж чадвал бага мөнгөөр их ажил бүтээн байгуулж үр шимийг хүртэж чаддагийг харуулсан, бусад малчдад үлгэр дурайлал болсон ажил болсон байна

Хөрөнгө оруулалтын зарцуулалт

Төслийн санхүүжилтийг юунд зарцуулсан талаар доорх хүснэгтэнд мэдээлэл оруулна

№	Хөрөнгө оруулалтын зарцуулалт	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт, төг
1	Голыг боох КОВШ тракторын	Мот\цаг	10	60 000	600 000
2	шуудай	ш	100	1000	100 000
3	Бууц буулгах	тн	15	20000	300 000
4	Шуудуу татах	м	200	3000	600 000
5	Хайлаах усалгаа	Хүн\өдөр	5.6.7.8-	300 000	1 200 000
6	Үрийн үнэ	тн	0.3	1200	360 000
7	бусад				330 000
	Нийт				3,490,000

Борлуулалт, үйлчилгээний орлого

Төсөл хэрэгжсэнээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үзүүлсэн үйлчилгээ, тэдгээрээс олсон орлогын талаар энэ хүснэгтэнд мэдээлэл оруулна.

№	Бүтээгдэхүүн, үйлчилгээ	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт, төг
	Машин өвс	ш	5	600,000	3000 000
	Нийт				3,000,000
	Нийт				

ТӨСЛИЙН ҮР ДҮН

Төсөл хэрэгжихээс өмнөх үетэй харьцуулахад төсөл хэрэгжсэнээр гарсан үр дүнгүүдийг тодорхой тоо баримттай, график дүрстэй оруулна. Үүнд:

- ↑ Цэвэр ашиг, хадлангийн зардалуудаас заримыг хэмнэсэн ба гар аргаар усалгаа хийж 1,000,000 төгрөгийн ашигтай ажилласан.
- ↑ Нийгмийн ашиг тус: Айл өрхүүдийн авах хадлангийн хэмжээ ихэссэнээр өрхийн орлого нэмэгдэж, малчдад нэмэлт орлого олох боломж олгосон. Тэжээлд зарцуулах мөнгөө бүрэн хэмнэж чадсан.

Уг төсөл хэрэгжсэнээр энэ жил 5 машин буюу 10тн овъёос хадаж авсан. Анхны жилд тариалсан учир ашиг багатай ажилласан юм.

ТӨСЛИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧ

Төслийн үр шимийг хүртсэн нэг болон нэлээн хэдэн хүн, байгууллагын өөрсдийнх нь ярьсан яриаг тухайн хүний харъялагдах аймаг, сум, байгууллага, БАХ-ийн нэр, овог нэртэй нь бүтэн оруулж бичнэ. Зураг оруулна.



ТУРГЫН БАХ-ын ахлагч И.Сагатбек:

Манай “Турган” БАХ-д Ногоон алт, малын эрүүл мэнд төслийн хүрээнд хэрэгжиж байгаа ногоон тэжээл тариалах төслийн ажил амжилттай хэрэгжиж, БАХ-ын малчдад өндөр ашиг шим хүртэж байгаад нь малчид бид маш их баяртай байна. Тус төслийн ачаар олон ч малчин айл өрхийн орлого нэмэгдсэн. Мөн жилд малын хөл хөдөлгөөний улмаас авах өвс маань сайнгүй байдгаас олон машин өвс авч зарж борлуулах байтугай өвлийн бэлтгэлээ базаахад хэцүүхэн байдаг

байлаа шүү. Тэгсэн энэ жилээс анх удаа овьёс тариалсны ачаар илүү гарсан 5 машин овьёс зарж ашигтай ажилласан. Тиймээс уг төслийг санаачлан хамтран хэрэгжүүлсэн Тургын БАХ-ын малчин өрхүүдэд баярлаж талархсанаа илэрхийлье. Бусад малчид хэсэг, бүлгүүд жишээ авч хамтарч ажлахыг хүсье.

Тургын БАХ-ын малчин Х.Сиражат: Манай бүлгийн 10 гаруй малчид хөрөнгө хүчээ нэгтгэн 2 га хадлангийн талбайгаа 3 490 000 төгрөгөөр овьёос тариалж их ургац авсандаа маш их баярлаж байна. Олны хүч оломгүй далай гэдэг үг үнэн байна. Тус хадлангийн талбайд ойрхон зусдаг зарим айлуудын бод, адуу мал байнга орж идэж, сүйтгэдэг байлаа. Малчдын хэсэг, бүлгийн зохион байгуулалтанд оруулж хамтарч ажилласаны ачаар, зусланд нүүлгэж том ажлыг хийж чадлаа гэж бодож байна. Тус ажлыг хийж гүйцэтгэхэд мөнгөн хөрөнгийн болон малчдыг нэгтгэн зохион байгуулалтанд оруулахад тусалсан сумын малчдын байгууллага, Ногоон алт, малын эрүүл мэнд төслийнхэнд маш их баярлалаа.

ТӨСЛИЙН ЗОРИУЛАЛТ

Төслийн зориулалт, зарцуулалт өөрчлөгдсөн бол учир шалтгааныг тодорхой бичиж ирүүлнэ